

**БАЯНТҮМЭН СУМЫН ЕБСУРГУУЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

ХУГАЦАА 60 МИНУТ

НИЙТ ОНОО 24

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ:УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

САНАМЖ: Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар 1 оноотой.

“А” хувилбар**Халуун гурил**

Намайг бага байхад ах минь гурил зуурч, эгч элдэнэ. Ахын зуурсан гурил цав цагаан, голын захын чулуу шиг мөлгөрхөн хавтгай, бариад үзэхэд бүлээхэн байдаг сан.

Ах минь дайнд яваад эргэж ирээгүй. Тэгээд би гурил зуурч сурсан юм. Миний зуурсан гурил бас л цав цагаан, голын захын чулуу шиг мөлгөрхөн боловч ер халуун болдоггүй байлаа. Эгч маань ахын зуурсан гурилыг шууд элддэг атлаа миний зуурсан гурилыг нухаж байж элдэх нь гагцхүү халуун хүйтний зөрүүнд л байна даа гэж би боддог байв. Тэгээд нэг өдөр гурилаа халуун болтол нь нухахаар шийдлээ. Эртээ гэгч гурилаа зуураад, эгчийн үнээгээ сааж байх хооронд нь удаан гэгч нухаж билээ. Нухсаар байтал би өөрөө их л халууцан, гурил ч бүлээн болох шиг санагдав. Эгч миний гурилыг авч эргүүлэн тойруулан дарж үзээд, над руу харж инээмсэглэн нухалгүй элдэж орхилоо. Би ч халуун гурил зуурсандаа ихэд баясан, ахын дайтай болсон шиг санаж явжээ.

Энэ гурилыг би өчнөөн ядарч бүлээн болгов. Гэтэл ах минь хормын дотор халуун болгодог мөн ч бүлтэй хүн байж дээ гэж би бодно. Энэ тухайд эгчдээ хэлбэл, тэрээр сүүгээ самрах зуур уртаар санаа алдсанаа, ахтайгаа улам адилхан болж өсөж байгаа дүү намайгаа ширтэн инээмсэглэхэд, сэтгэл нь өрөмтөн байгаа сүү шиг хөөсөрч байлаа.

1. Дүү нь ямар учраас гурил зуурч сурсан бэ? \ 1оноо

А. Эгчдээ туслахыг хүссэн учраас

Б. Ах шигээ ажилтай болохыг хүссэн учраас

В. Эгч нь гурил элдэх учраас

Г. Ах нь дайнд яваад, эргэж ирээгүй учраас

2. “Би ч халуун гурил зуурсандаа ихэд баясан, ахын дайтай болсон шиг санаж явжээ”. Өгүүлбэрийн тодруулсан үгийн утгатай тохирох нь аль вэ? \ 1оноо

А. ахтайгаа адилхан болжээ.

Б. ахаасаа том болжээ.

В. ахаасаа илүү ажилтай болжээ.

Г. ахтайгаа дүйцэхүйц ажилтай болжээ.

3. Өгөгдлүүдийг ажиглаад, зөв дарааллыг олж тэмдэглээрэй. \ 1оноо

Нухсаар байтал би өөрөө их л халууцан, гурил ч бүлээн болох шиг санагдав.

Тэгээд би гурил зуурч сурсан юм.

Энэ гурилыг би өчнөөн ядарч бүлээн болгов.

Эртээ гэгч гурилаа зуураад, удаан гэгч нухаж билээ.

Ах минь дайнд яваад эргэж ирээгүй.

а. А. 5,2,1,4,3

Б. 5,3,1,2,4

В. 5,2,4,1,3

Г. 5,3,4,1,2

4. “... ах минь хормын дотор халуун болгодог мөн ч бүлтэй хүн байж дээ гэж би бодно.” гэсэн өгүүлбэрийн тодруулсан үгийн ойролцоо утгатай үг аль нь вэ? \ 1оноо

А. чадалтай

Б. ам бүл олонтой

В. бүлээн гартай

Г. ажилсаг

5. Зөв бичигдсэн үг аль вэ? / 1 оноо/

А. цацачхаад

б. цацчихаад

в. цацачихаад

г.цацчахаад

6. Үйлт нэрийн –х-ийн өмнөх балархай эгшиг гээгдэхгүй дүрмээр бичигдсэн үг аль нь вэ? / 1 оноо/

А. сайхан

Б. сонирхон

В. Дуулах

7. Үгийн дунд орсон л.м.н,в үсгийн дараа алийг бичих вэ? / 1 оноо/

А. Б бичнэ

Б. В бичнэ

В. аль алиныг бичнэ.

8. Бусдад хандаж тэднийг сайн сайхан зүйлд уриалж дуудаж бичсэнийггэнэ. / 1 оноо/

А. урилга

Б. талархал

В. Уриалга

9. Аль нь балархай эгшгийн зөөлрүүлэх үүргээр бичигдсэн бэ? / 1 оноо/

А. булаг

Б. болхи

В. Булга

**БАЯНТҮМЭН СУМЫН ЕБСУРГУУЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

ХУГАЦАА 60 МИНУТ

НИЙТ ОНОО 24

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ:УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

САНАМЖ: Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар 1 оноотой.

“Б” хувилбар**Халуун гурил**

Намайг бага байхад ах минь гурил зуурч, эгч элдэнэ. Ахын зуурсан гурил цав цагаан, голын захын чулуу шиг мөлгөрхөн хавтгай, бариад үзэхэд бүлээхэн байдаг сан.

Ах минь дайнд яваад эргэж ирээгүй. Тэгээд би гурил зуурч сурсан юм. Миний зуурсан гурил бас л цав цагаан, голын захын чулуу шиг мөлгөрхөн боловч ер халуун болдоггүй байлаа. Эгч маань ахын зуурсан гурилыг шууд элддэг атлаа миний зуурсан гурилыг нухаж байж элдэх нь гагцхүү халуун хүйтний зөрүүнд л байна даа гэж би боддог байв. Тэгээд нэг өдөр гурилаа халуун болтол нь нухахаар шийдлээ. Эртээ гэгч гурилаа зуураад, эгчийн үнээгээ сааж байх хооронд нь удаан гэгч нухаж билээ. Нухсаар байтал би өөрөө их л халууцан, гурил ч бүлээн болох шиг санагдав. Эгч миний гурилыг авч эргүүлэн тойруулан дарж үзээд, над руу харж инээмсэглэн нухалгүй элдэж орхилоо. Би ч халуун гурил зуурсандаа ихэд баясан, ахын дайтай болсон шиг санаж явжээ.

Энэ гурилыг би өчнөөн ядарч бүлээн болгов. Гэтэл ах минь хормын дотор халуун болгодог мөн ч бүлтэй хүн байж дээ гэж би бодно. Энэ тухайд эгчдээ хэлбэл, тэрээр сүүгээ самрах зуур уртаар санаа алдсанаа, ахтайгаа улам адилхан болж өсөж байгаа дүү намайгаа ширтэн инээмсэглэхэд, сэтгэл нь өрөмтөн байгаа сүү шиг хөөсөрч байлаа.

1. Дүү хөлсөө гартал гурилаа нухсаны учир юу вэ? \ 1оноо\

А. Ахын дайтай болохын тулд	Б. Эгч зуурсан гурилыг нь дахин нухдаг учраас
В. Эгч үнээгээ сааж байсан учраас	Г. Эртээ гурилаа зуурсан учраас
2. Эхийн гол санааг оновчтой илэрхийлсэн зүйр үг аль нь вэ? \ 1оноо\

а. Хүний сайныг ханилж мэднэ	б. Хүний эрээн дотроо
Хүлгийн сайныг унаж мэднэ.	Могойн эрээн гаднаа
в. Ажил хийж хүн болдог	г. Хошуу нэмэхээр
Ар давж хүлэг болно.	Хуруу нэмэх
3. Өгөгдлүүдийг ажиглаад, зөв дарааллыг олж тэмдэглээрэй. \ 1оноо\
 1. Нухсаар байтал би өөрөө их л халууцан, гурил ч бүлээн болох шиг санагдав.
 2. Тэгээд би гурил зуурч сурсан юм.
 3. Энэ гурилыг би өчнөөн ядарч бүлээн болгов.
 4. Эртээ гэгч гурилаа зуураад, удаан гэгч нухаж билээ.
 5. Ах минь дайнд яваад эргэж ирээгүй.

А. 5,2,1,4,3	Б. 5,3,1,2,4	В. 5,3,4,1,2	Г. 5,2,4,1,3
--------------	--------------	--------------	--------------
4. “Эртээ гэгч гурилаа зуураад, эгчийн үнээгээ сааж байх хооронд нь **удаан** гэгч нухаж билээ.” өгүүлбэрийн тодруулсан үгнүүд юуг заан нэрлэсэн утгатай үгс вэ? \ 1оноо\

А. орон байрыг заасан	Б. өнгө заасан	В. цаг хугацааг заасан	Г. тоо хэмжээг заасан
-----------------------	----------------	------------------------	-----------------------
5. **Зөв бичигдсэн үг аль вэ? / 1 оноо/**

А. гацачхаад	б. гацчихаад	в. гацачихаад	г.гацчахаад
--------------	--------------	---------------	-------------
6. **Үйлт нэрийн –х-ийн өмнөх балархай эгшиг гээгдэхгүй дүрмээр бичигдсэн үг аль нь вэ? / 1 оноо/**

А. сайхан	Б. сонирхон	В. уйлах
-----------	-------------	----------
7. **Үгийн дунд орсон л.м.н,в үсгийн дараа алийг бичих вэ? / 1 оноо/**

А. Б бичнэ	Б. В бичнэ	В. аль алиныг бичнэ.
------------	------------	----------------------

8. Бусдад хандаж тэднийг сайн сайхан зүйлд уриалж дуудаж бичсэнийггэнэ. / 1 оноо/

- А. урилга Б. талархал В. Уриалга

9. Аль нь балархай эгшгийн зөөлрүүлэх үүргээр бичигдсэн бэ? / 1 оноо/

- А. булаг Б. болхи В. Булга

10. “ба”, “бөгөөд” холбох үгээрхолбодог. / 1 оноо/

- А. нэг төрлийн үг, өгүүлбэрийг зэрэгцүүлж холбодог.
Б. өгүүлбэр ба цогцолборуудыг холбодог.
В. эхүүдийг хооронд нь холбодог

2-р хэсэг:БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

1. Дараах үгсийг зөв байрлуулж утга төгс өгүүлбэр бүтээгээрэй. / 2 оноо/

\Хая, хаяа, хааяа, хаая\

Тэнгэрийн оройн нарны туяанд улааран харагдана.

Чи муу зуршлаа заавал Би даалгавраа хийхээ мартдаг. Гадаа утаа ихтэй байгаа учраас цонхоо

2. Дараах үгсэд – я, е, ё залгаарай. / 2 оноо/

тогло.....

хүндэл.....

яв.....

хаа.....

3. Алдаатай бичсэн үгийг засч бичээрэй. / 3 оноо/

гэрийн буур тэмээний Буйр буурь нуур

4. Дараах үгийг олон тоонд хувиргаарай. / 2 оноо/

дуучин-..... тариачин-

5. Найздаа зориулж өөрийн төрсөн өдрийн урилгыг бичнэ үү? / 5 оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Сурагчийн нэр: